



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар АНЗ

Баян-Адарга сум

Ой, хээрийн түймрээс урьдчилан  
сэргийлэх, тэмцэх зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний тухай удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 17 дугаар зүйлийн 17.2.13 дахь заалт, 18.2.5, 18.2.13, 18.2.14 дэх заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.14 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 106 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээний 2026 оны “Ой хээрийн түймрийн цаг агаарын нөхцөл байдлын зэрэг”-ийг харгалзан 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ой, хээрийн бүсэд аялал зугаалга хийх, эрсдэл бүхий газарт нийтийг хамарсан ажил зохион байгуулах, ойгоос мод бэлтгэх, тээвэрлэх, ахуйн зориулалтаар ан агнах, загас барих, байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүх үйл ажиллагааг хориглосугай.

2. Ойг тарьж ургуулах, нөхөн сэргээх, мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдтэй түймрийн аюултай улиралд ажиллах хариуцлагын гэрээ байгуулан гал түймэр алдахгүй баталгааг гаргуулсны үндсэн дээр ойн аж ахуйн ажлыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Гүрбүрэн), Байгаль хамгаалагч (О.Батсуурь) нарт үүрэг болгосугай.

3. Ой хээрийн бүсэд ил задгай гал түлэхгүй байх зайлшгүй шаардлагаар түлсэн гал, түүний цог нурам, асаасан чүдэнз, татсан тамхины галыг бүрэн унтраах, эзэмшиж буй тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг хангасны үндсэн дээр ой, хээрийн бүсэд зорчих, хүн нэг бүрийн хамгаалах, гал түймэр унтраах багаж хэрэгслийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, нийт иргэд, малчид, тариаланчид, тээврийн хэрэгсэл эзэмшигч, жолооч нарт анхааруулсугай.

4. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааг сайтар зохион байгуулж, түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах зохион байгуулалтын ажлыг урьдчилан төлөвлөж сумын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажиллахыг Эрэн хайх

аврах салбарын Захирагч (ахмад Ц.Ганцог), Багийн Засаг дарга нар, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Гүрсүрэн), байгаль хамгаалагч (О.Батсуурь), замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган бүрэн бус буюу яндангийн оч баригчгүй, түймэр унтраах багаж хэрэгсэлгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавихыг Цагдаагийн хэсгийн Төлөөлөгч (С.Батсайхан) нарт тус тус даалгасугай.

5.Хуурайшилтын хугацааны үед нийт иргэд, байгууллагад рй хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, таниулга, сурталчилгааг хийж, хөдөлгөөнт эргүүл харуул томилон, иргэд, малчид, тариаланч, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас баталгаа гаргуулан ажиллахыг Эрэн хайх, аврах салбарын захирагч (ахмад Ц.Ганцог), багийн Засаг дарга нар, Байгаль хамгаалагчид, Мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Оюунтунгалаг) нарт даалгасугай.

6.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, тэмцэх үеийн санхүүгийн нөөцийг шийдвэрлэж, ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Бат-Эрдэнэ)-д, Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч, сумын Онцгой комиссын Орлогч дарга (Н.Ганбат)-д болгосугай.

~~ЗАСАГ ДАРГА~~ ~~О.ЛХАГВАДОРЖ~~

